



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 1197

Улаанбаатар хот

**Хан-Уул дүүргийн 46 дугаар
цэцэрлэгийн балансаас хөрөнгө
шилжүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 450,000 /дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийн хөрөнгийг Хан-Уул дүүргийн 29 дүгээр цэцэрлэгийн балансад шилжүүлж данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн 46 дугаар цэцэрлэг /Д.Энхбаатар/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэн авахыг Хан-Уул дүүргийн 29 дүгээр цэцэрлэг /Б.Энхтуяа/-т даалгасугай.


3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Хан-Уул дүүргийн 29 дүгээр цэцэрлэг /Б.Энхтуяа/, Хан-Уул дүүргийн 46 дугаар цэцэрлэг /Д.Энхбаатар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ОДНАСАН

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 05 сарын
 10 өдрийн 1/97 дугаар тушаалын хавсралт



ХУД-ийн 46 дугаар цэцэрлэгийн балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтанд орсон	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага	
1	Дээжний хөргөгч	Ү-BLG-685	Ү-BLG-686	2016.10.25	ш	1	450,000.00	450,000.00	271,875.00	178,125.00	ХУД-ийн 29 дүгээр цэцэрлэг	
Тоног төхөөрөмжийн дүн												
Нийт хөрөнгийн дүн									450,000.00	271,875.00	178,125.00	